



МОНГОЛ УЛС  
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 07 өдөр

Дугаар А/Р

Хэрлэн сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээг  
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, 30 дугаар зүйлийн 30.1.5, Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай нотлох баримтыг бүрдүүлэн гаргасан өргөдлийн дагуу иргэн Донойн Байгальмаагийн эзэмшлийн Хэрлэн сумын 5 дүгээр баг Мах-Экспортын зүүн урд талд байрлах, Үйлдвэрлэлийн зориулалттай 1500 м<sup>2</sup> газрыг иргэн Ганболдын Баярсайханд 27 жилийн хугацаатайгаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.


2. Иргэн Ганболдын Баярсайханы эзэмшил газрын кадастрын зураглалыг хавсралтаар баталсугай.

3. Газар эзэмших эрхийн гэрчилгээг олгон гэрээ байгуулж, биелэлтэд хяналттавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Д.Баярхүү/-т үүрэг болгосугай.

4. Газар эзэмших гэрээнд тусгагдсан зохиулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг иргэн Г.Баярсайханд үүрэг болгосугай.

5. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2011 оны 163 дугаар захирамжийн хавсралтыг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА